



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Давтан аудитын тайлан

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын 2007, 2008 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Зөвлөмжийг хэрэгжүүлснээр санхүүгийн үйл ажиллагаанд үр дүн гарсан байна

Тайланг бэлтгэсэн:

**ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар**

Захирал: Д.Ганбилэг

Аудитын
менежер: Х.Баярмаа

Аудитор: Ш.Отгонбаяр
Г.Гүнжидмаа

2010 оны 11 дүгээр сар

**Уг тайланг ҮАГ-ын Веб
сайт-аас үзнэ үү.**

www.mnao.mn

*Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 263533 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.*

ХАЯГ:

*Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-
46 Монгол Улс*

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4

- Зөвлөмж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулжээ..... 5

- 1008.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлагаас 70.0 сая төгрөгийн зөрчлийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна..... 9

- Актаар тавьсан төлбөрийг барагдуулсан байна..... 12

Аудитын дүгнэлт 13

Зөвлөмж 18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ННДГ	Нийслэлийн нийгмийн даатгалын газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын 2007, 2008 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд дүгнэлт өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Аудитаар өгсөн зөвлөмжүүд хэрэгжсэн эсэх
- Акт, албан шаардлагыг бүрэн барагдуулсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад УАГ-аас 2008 онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлагын дагуу зөрчлийг барагдуулах, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр УНДЕГ-аас зохион байгуулсан ажилтай холбоотой баримт материалыг хамруулсан болно.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Байгууллагын холбогдох албан тушаалтнууд, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах;
- Цуглуулсан баримт, материалд дүн шинжилгээ хийх;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

Зөвлөмж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулжээ

Зөвлөмжийн хэрэгжилтийг заалт бүрээр авч үзвэл:

Зөвлөмж 1. Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах асуудлыг зохицуулах дүрэм журам боловсруулж мөрдүүлэх

- “Журам батлах тухай” НДҮЗ-ийн 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ыг баталж, 2009 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 33 дугаар тогтоолоор дээрх журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- Мөн НДҮЗ-ийн 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгөөр Засгийн газрын бонд худалдан авах тухай журам”-ыг баталжээ.

Дээрх журмуудыг баталснаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг банкинд байршуулах, өсгөх талаар удирдлагын үүрэг, хариуцлагыг тусгасан эрх зүйн акттай болсон байна.

Зөвлөмж 2. УНДЕГ-ын даргатай байгуулах үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, хариуцлагыг сайжруулах

НХХС-тай УНДЕГ-ын даргын байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд яамнаас хяналт хийж сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэж үнэлгээ өгч, цаашид анхаарах асуудлуудаар үүрэг даалгавар өгч ажилласан байна. Мөн УНДЕГ-ын үйл ажиллагааны хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж байна.

УНДЕГ үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, түүнд хяналт тавих зорилгоор УНДЕГ-ын даргын 2010 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 7 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтэс, аймаг /нийслэл/-ийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”, нийгмийн даатгалын ерөнхий газрын газар, хэлтэс болон аймаг /нийслэл/-ийн нийгмийн даатгалын хэлтэс, газрын үйл ажиллагааны үр дүнг дүгнэх үзүүлэлт, УНДЕГ-ын “Ажилтнуудын өөрийн үнэлгээний тайлан”-гийн загварыг батлан, түүнийгээ мөрдөж байна.

Зөвлөмж 3. Нийгмийн даатгалын төв байгууллагын орон тоо, зохион байгуулалтын бүтцийг оновчтой тодорхойлон удирдлагын шат дамжлагыг багасгах арга хэмжээ авах

УНДЕГ 2008 онд 107 орон тоотойгоор ажиллаж байсан бол ЗГ-ын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 80 дугаар тэмдэглэлд орон тооны дээд хязгаарыг 85 байхаар заасан байна.

Мөн НДҮЗ-ийн 2009 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар тогтоолоор УНДЕГ-ын бүтцийг шинэчлэн баталжээ.

Дээрх шийдвэрийг үндэслэн “Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаал, орон тоог шинэчлэн батлах тухай” УНДЕГ-ын даргын 2009 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 28 дугаар тушаалаар баталсан 84 орон тоотой ажиллаж байна.

Бүтэц орон тоог шинэчилснээр УНДЕГ-ын газрын орлогч дарга, мониторинг үнэлгээний алба, хяналт шалгалтын алба, БНСУ дахь нийгмийн даатгалын албаны даргын орон тоог цомхотгожээ.

Зөвлөмж 4. Нийгмийн даатгалын сангаас зарцуулах үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж батлуулах, төсвийн гүйцэтгэлийн нэр төрлөөр хийх хяналтыг тогтмолжуулах

НДҮЗ-ийн 2009 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсвийг боловсруулахад баримтлах аргачлалыг баталжээ.

Мөн сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах зорилгоор аймаг, нийслэл, дүүргийн НДХ-ийн эдийн засагч нарын сургалтыг зохион байгуулж, 2010 оны төсвийн төсөл, 2011, 2012 оны төсвийн төсөөллийг боловсруулах, төсвийн төслийг цаг хугацаанд ирүүлэх үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллажээ.

Зөвлөмж 5. Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэлийг гаргаж тайлагнах

НДҮЗ-ийн 2009 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар ҮАГ-аас УНДЕГ-ын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр зохиосон ажлын тайлан танилцуулгыг хэлэлцэж, үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Мөн НДҮЗ-ийн ээлжит хуралдаанаар 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан Чингэлтэй дүүргийн НДХ-ийн барилга барих асуудлыг хэлэлцэж тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах баригдсан болон дуусаагүй барилга худалдан авах шийдвэр гаргасан байна.

НДҮЗ нийгмийн даатгалын байгууллагуудын хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөгөөг баталж, 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө УНДЕГ-ын газар, хэлтэс тус бүрийн ажлын тайлан мэдээллийг хэлэлцэхээр тусгасны дагуу нийгмийн даатгалын байгууллагуудын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг хэлэлцсэн байна.

Зөвлөмж 6. НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, төв сангийн болон үйл ажиллагааны бүртгэлийн программ хангамжийг сайжруулах

“Нийгмийн даатгалын байгууллагын бодлогын баримт бичиг батлах тухай” УНДЕГ-ын 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 396 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичгийн зааврыг баталж, 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөн, ажиллаж байна.

Зөвлөмж 7. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, цаашид давтан гаргуулахгүй байх, хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдсэн боловч гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй, дуусаагүй барилга байгууламжийн ажлын гэрээг дүгнэж, биелэлтийг хангуулах

Гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй байсан Ховд, Завхан аймаг, Баянгол дүүргийн НДХ-ийн болон Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нийгмийн даатгалын тасгийн конторын барилгыг ашиглалтад оруулсан байна.

Зөвлөмж 8. Арилжааны банкуудтай байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээг зах зээлийн түвшинд нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

2008 оны эхний хагас жилд 7 банкинд 40.3 тэрбум төгрөгийг 1-3 жилийн хугацаатай жилийн 4.8-6.0 хувийн хүүтэй хадгалуулахаар гэрээ байгуулан байршуулсан байжээ.

2008 оны 2 дугаар улирлын тайлангаарх сангийн мөнгөн хадгаламжийн байршлыг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

д/д	Гэрээ байгуулсан арилжааны банкны нэр	Гэрээний хугацаа	Хадгаламжийн хүү(жилээр)	Байршуулсан мөнгөн хадгаламж
1	Улаанбаатар хотын банк	3 жил	4,8	9 200,0
2	Капитал банк	3 жил	4,8	14 000,0
3	Капитрон банк	2 жил	4,8	6 000,0
4	Монгол шуудан	2 жил	6,0	3 100,0
5	Зоос банк	1 жил	4,8	1 000,0
6	Зоос банк-106	1 жил	4,8	2 000,0
7	Анод банк	2 жил	4,8	2 000,0
8	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2 жил	6,0	3 000,0
	Дүн			40 300,0

Дээрх банкуудаас Улаанбаатар хотын банк, Зоос банкуудтай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Бусад банкуудтай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж хадгаламжийн хүүг 6.1-11.5 хувь болгосноор хүүгийн орлого 1005.2 сая төгрөгөөр нэмэгдсэн тооцоо гарчээ.

2008 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө байршуулсан хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүү 5.05 хувь, жигнэсэн дундаж хугацаа 2.3 жилийн хугацаатай байсан бол 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 75.8 тэрбум төгрөгийн хадгаламжийн жилийн жигнэсэн дундаж хүү 9.3 хувь, жигнэсэн дундаж хугацаа 1.2 жил болж өөрчлөгдсөн байна.

Харин Анод банкинд УНДЕГ-ын харилцах болон хадгаламж хэлбэрээр байршиж байсан 2.7 тэрбум төгрөгийг “Актив пассив хөрөнгө шилжүүлэх тухай” 2010 оны

10 дугаар сарын 20-ны өдрийн 198/2010 эха/1/229/28 дугаар гэрээгээр Хадгаламж банкинд байршуулжээ.

Зөвлөмж 9. Дотоодын болон хөндлөнгийн хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, маягт, үнэт цаасны болон бусад орлогыг нэгтгэсэн тайланд тусгах

УНДЕГ-ын 2009 оны 106 дугаар тушаалаар нийгмийн даатгалын үйл ажиллагаанд хэрэглэгдэх маягт, үнэт цаас борлуулсны болон бусад орлого, зарцуулалтыг 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагааны санхүүгийн тайлан тэнцэлд тусган тайлагнаж байхыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт даалгасан байна.

Мөн маягт худалдан борлуулахтай холбоотой гарах бүртгэлийн бичилтүүдийг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаж, түүнийгээ мөрдөн ажиллаж байна.

Зөвлөмж 10. Орон сууцны дэмжлэгт хамрагдагсдын судалгаа, мэдээллийн сантай болж, хэт хавтгайруулж, давхардуулан олгохыг зогсоох

НДҮЗ-ийн 2009 оны 15 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг орон сууцаар хангах, нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгох журам”-ыг баталж, 2010 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 6 дугаар тогтоолоор журамд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан байна.

Уг журмын дагуу ажлын хэсэг байгуулан УНДЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн газрын даргын тушаалаар 2009 онд 2 удаа 136 ажилтанд 698.9 сая төгрөг, 2010 онд 90 ажилтанд 453.5 сая төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгосон байна.

Нийгмийн даатгалын байгууллагуудын хэмжээнд орон сууцны дэмжлэгт хамрагдсан ажилтнуудын судалгаа, мэдээллийн сантай болсон нь ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх нийгмийн асуудлыг шийдвэрлэх үйл явцыг ил тод, тэгш болгож, дэмжлэгийг хэт хавтгайруулан, давхардуулан олгодог явдлыг зогсоох талаар үр дүнтэй ажил болжээ.

Зөвлөмж 11. НДШ-ийн өрөнд авсан барилга, объектын түрээсийн болон худалдах, худалдан авах гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, шаардлагатай гэж үзвэл зарим гэрээг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

НДШ-ийн өрөнд хураагдсан бараа материалыг актлаж устгах, бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, дахин үнэлүүлэх санал боловсруулахаар байгуулагдсан ажлын хэсгийн саналыг НДҮЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргажээ.

Мөн түрээсийн төлбөрийн маргаантай байгаа аж ахуйн нэгжүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгүүдийг томилон ажиллуулж байна.

1008.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлагаас 70.0 сая төгрөгийн зөрчлийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна

Аудитаар илэрсэн зөрчилд өгөгдсөн дараахь албан шаардлагын биелэлтийн байдал:

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас үйл ажиллагааны зардалд буюу ажиллагсдын орон сууцны дэмжлэгт зарцуулсан 120000.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх

“Акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх тухай” УНДЕГ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 407 дугаар тушаалын дагуу 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1946 дугаар төлбөрийн хүсэлтээр Эрүүл мэндийн даатгалын сангийн төрийн сан банкны 900090003 тоот дансанд 120000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

2. УНДЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй боловч 2005 оноос хойш НХХЯ-д ашиглагдаж байгаа Ланд круйзер-105 маркийн 06-78 УБЗ дугаартай автомашиныг хөрөнгөд бүртгэх

НДҮЗ-ийн ажлын хэрэгцээнд ашиглаж байсан уг автомашиныг УНДЕГ 2009 оны 1 дүгээр сард хүлээн авч, орон нутагт явах албан ажлын хэрэгцээнд ашиглаж байна. Тээврийн хэрэгслийг комисс хүлээн авч акт үйлджээ.

3. Үндсэн хөрөнгө, эд хогшилд гэнэтийн тооллого хийхэд 6056.8 мянган төгрөгийн хөрөнгө эд хариуцагч нярваас дутагдсаныг төлүүлэх

- 5 нэр төрлийн 2456.8 мянган төгрөгийн эд хөрөнгийг нярваар ажиллаж байсан Д.Энхцэцэгээс авсан
- 2281.3 мянган төгрөгийн хөрөнгийг УНДЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Эрдэнээс авахаар авлагаар бүртгэсэн
- 1300.0 мянган төгрөгийн сийлбэрийг авлагаар бүртгэсэн

4. 2007 оны жилийн эцсийн тооллогоор дутагдсан 1246.4 мянган төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх

Тайлангийн төсөлд санал авах хугацаанд 2004 оноос хойшхи хугацааны анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг нэг бүрчлэн тулган үзэж 2005 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн үнийн зөрүүгийн орлогоор 1246.4 мянган төгрөгийг давхардуулан тусгасан нь холбогдох баримтаар нотлогдсон тул 2010 оны 12 дугаар сарын 15-нд 1246.4 мянган төгрөгийг залруулах бичилт хийжээ.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэрээр Сонгинохайрхан дүүргийн НДХ шимтгэлийн өрөнд авсан 13000.0 мянган төгрөгийн автомашиныг данс бүртгэлд тусгах

Автомашиныг ННДГ үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй байна. Харин НДҮЗ-ийн тогтоолоор уг автомашиныг дуудлага худалдаагаар борлуулахаар шийдвэрлэж, хоёр удаа дуудлага худалдааны зарыг “Өнөөдөр” сонинд нийтлүүлсэн боловч оролцогч ирээгүй учраас дахин зар өгсөн байна.

6. Төв сангийн НДШ-ийн өрөнд авсан барааг хүлээлцүүлэхдээ тооллого хийж баталгаажуулаагүй, эд хариуцагчийн бусдад худалдсан бараа, материалын үнэ төлөгдөөгүй 3568.8 мянган төгрөгийг төлүүлэх

УНДЕГ-ын Санхүү бүртгэлийн газар нь тайлангийн төсөлд санал авах хугацаанд тухайн үед эд хариуцагчаар ажиллаж байсан одоо Сонгинохайрхан дүүргийн НДХ-т орлого, шимтгэлийн байцаагчийн ажилтай С.Туяатай төлбөр барагдуулах график байгуулсан байна. УНДЕГ-аас 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 5/2830 дугаар албан бичгээр төлбөрийг цалингаас нь суутган холбогдох дансанд төвлөрүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн НДХ-т мэдэгдсэн байна.

7. НДШ-ийн өрөнд авсан барилга объектын түрээсийн 105000.0 мянган төгрөгийг түрээслэгч “Ар Пи Эм” ХХК барилгын засварын үнэнд тооцсоныг төлүүлэх

УНДЕГ 2010 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/181 дүгээр албан бичгээр тус компанийн 2007 онд байгуулсан “Үл хөдлөх хөрөнгийг түрээсээр ашиглуулах” гэрээг зөрчиж барилгын засварт зарцуулсан 215.5 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэн байна.

Мөн 2010 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 5/1414 дүгээр албан бичгээр гэрээгээ шинэчлэх, түрээсийн тооцоог алдангийн хамт барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах шаардлагатай байгааг мэдэгдээд, уг объектыг дуудлага худалдаагаар худалдах болсонтой холбогдуулж түрээсийн төлбөрөө 2010 оны 6 дугаар сард багтаан барагдуулахыг шаардсан боловч “Ар Пи Эм” ХХК засвар хийсэн гэсэн шалтгаанаар өнөөг хүртэл түрээсийн төлбөрөө төлөөгүй байна.

Уг объектыг НДҮЗ-ийн 2010 оны 8 дугаар сарын 25-ны 14 дүгээр тогтоолоор дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарсны дагуу УНДЕГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг уг объектыг “Хөрөнгө үнэлгээний төв” ХХК-иар хөрөнгийн дахин үнэлгээ хийлгүүлэн, дуудлага худалдаагаар худалдан борлуулах бэлтгэл ажлыг хийж байна.

8. 2000 онд Зоос банкинд шилжүүлсэн гэх хуурамч баримт бүрдүүлэн Алтжин ХХК-д шилжүүлсэн 220000.0 мянган төгрөгийг аудитын дүгнэлтээр авлагаар тусгаагүй, дээрх мөнгөнд тооцсон хүү 106900.0 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах

УНДЕГ уг асуудлыг хянан шалгаж өгөх хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт гаргасны дагуу эрүүгийн 20746339 дугаартай хэрэг үүсгэн шалгаж, 2010 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн прокурорын газарт шилжүүлж одоо Сонгинохайрхан дүүргийн шүүхэд хянагдаж байгаа гэсэн албан бичгийг тус газраас ирүүлсэн.

9. Зоос, Улаанбаатар банкнаас 119169.5 мянган төгрөгийг хүүгийн авлага үүсгэж аваагүй (дотоод хяналтаар)

Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар хүсэлт гаргаж 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 8/2674 дугаар албан бичиг хүргүүлсэн байна.

УНДЕГ-ын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 2/2914, Зоос банкны эрх хүлээн авагчаас 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн 2964 дүгээр албан бичгээр 2006, 2007 онд Зоос банкны 106 дугаар салбараас УНДЕГ-ын харилцах дансны үлдэгдэлд 89463.6 мянган төгрөгийн хүүг төлсөн, тухайн онуудад үүссэн өглөг, авлагын тооцоо байхгүй болохыг тодорхойлж холбогдох баримтыг ирүүлжээ.

Харин Улаанбаатар банк манай газраас явуулсан албан бичгийн хариуг ирүүлээгүй ба УНДЕГ-аас ирүүлсэн албан бичгээр 16.4 сая төгрөгийн хүү төлсөн болохыг тодорхойлж байгаа нь албан шаардлагаар тавьсан зөрчлийн дүнтэй тохирохгүй байгаа тул Улаанбаатар банкнаас хүүгийн авлага үүсгэж аваагүй 70000.0 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

10. Орон сууцны дэмжлэгийг 19 хүнд давхар олгосон 58000.0 мянган төгрөг, харъяалалгүй хүмүүст олгосон 53050.0 мянган төгрөг, орон сууцны дэмжлэгийг журам зөрчиж олгосон 104200.0 мянган төгрөг, нийт 215250.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, журамлах

2009 оноос ажилтнуудад олгох орон сууцны дэмжлэгийг “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг орон сууцаар хангах, нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгох журам”-ын дагуу шийдвэрлэж байна.

11. УБ хотын даатгал ХХК-иас нөхөн төлбөрт олгосон 13016.0 мянган төгрөгийг авлагаар тусгах

2009 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 1/1144 дүгээр албан бичгээр уг асуудлыг шалгаж шийдвэрлэж өгөхийг Авлигатай тэмцэх газарт хүссэн байна.

Мөн энэ асуудлыг шалгуулахаар Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч, НДҮЗ-ийн гишүүн С.Ганбаатараас Авлигатай тэмцэх газарт 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 1/171 дугаартай албан бичиг ирүүлснийг тус газраас “Дээрх үйлдэл нь Цагдаагийн байгууллагын харьяаллын хэрэг байх тул тухайн асуудлыг Цагдаагийн байгууллагад хандана уу” гэж 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 06/1257 дугаартай албан бичгээр хариу өгсөн байна.

Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой баримтыг УНДЕГ-аас дахин нягтлан үзэж Говьсүмбэр аймгийн НДХ-ийн байранд гал гарсны улмаас үүссэн хохирлын 1791.0 мянган төгрөгийг Улаанбаатар даатгал ХХК-иас тус хэлтэс 2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч бүртгэл, тайланд тусгасан баримтыг ирүүлсэн байна.

Говьсүмбэр аймгийн НДХ-ийн халаалтын зуух дэлбэрснээс үүссэн хохирлын 5500.0 мянган төгрөгийг 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар даатгал ХХК-иас авах авлагаар тусгасан байна.

Мөн 2003 онд Мэдээлэл тооцоолол, сургалтын төвийн техник тоног төхөөрөмжийг зассантай холбоотой гарсан зардал 5725.0 мянган төгрөгийг Улаанбаатар даатгал ХХК-иас даатгалын нөхөн төлбөрт төлсөн боловч тус газар болон холбогдох нэгжүүд хүлээн аваагүй хуурамч баримт бүрдүүлэн санаатайгаар шамшигдуулсан гэж үзэн асуудлыг 2010 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хууль хяналтын байгууллагад шилжүүлэхийг тус төвд УНДЕГ-аас албан бичгээр үүрэг болгосон байна.

12. Бизнес зуучлалын алба (хуучин нэрээр)-нд НДШ-ийн өрөнд авсан орон сууцны үнэ 15900.0 мянган төгрөгийг иргэн Загдсүрэнгээр, 9300.0 мянган төгрөгийг Н.Отгонбаяраар төлүүлэх арга хэмжээ аваагүй

Н.Отгонбаяраар 2008 онд 7700.0 мянган төгрөг, 2009 онд 1600.0 мянган төгрөг нийт 9300.0 мянган төгрөгийг төлүүлсэн байна.

Харин Д.Загдсүрэнгийн хаягийг тодруулахаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2010 оны 10 дугаар сарын 22-нд албан бичиг явуулж хаягийг тодруулан холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Баянгол дүүргийн шүүхэд 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 2/2508 дугаар албан бичгээр нэхэмжлэл гаргасан байна.

13. Иргэн Дариймаад олгосон зээл 1500.0 мянган төгрөгийг төлүүлэх арга хэмжээ аваагүй

Авлигатай тэмцэх газарт мөн хүсэлт гаргаж шалгуулсан боловч хуульд заасан хохирлын хэмжээ хүрэхгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох санал үйлдэж прокурор шийдвэрлэсэн байна.

УНДЕГ Н.Дариймаагийн хаягийг тодруулан Баянзүрх дүүргийн шүүхэд 2010 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/2509 дугаар албан бичгээр нэхэмжлэл гаргажээ.

14. УНДЕГ-ын маягт, үнэт цаасны данснаас 2008 оны 4 дүгээр сард тендерийн үйл ажиллагаанд зориулах төсвөөр хувилагчтай принтерийг орлогод аваагүй

Хувилагч принтерийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаж орлого авчээ.


Актаар тавьсан төлбөрийг барагдуулсан байна

Үнэт цаас, маягтын данснаас бэлэн мөнгийг хуурамч баримтаар зарцуулсан, томилолтын мөнгийг давхардуулан олгосон 2029.9 мянган төгрөгийн актны төлбөрийг барагдуулсан.

**Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.
Үүнд:**

- Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах, Засгийн газрын бонд худалдан авах асуудлыг зохицуулах журмыг батлан мөрдөж ажилласнаар үр дүн гарчээ
- Орон сууцны дэмжлэгт хамрагдагсдын судалгаа, мэдээллийн сантай болж, дэмжлэг үзүүлэх журам баталсан байна
- НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлан маягт, үнэт цаасны орлогыг үйл ажиллагааны тайланд тусган тайлагнаж байна
- Албан шаардлагаар өгсөн 70.0 сая төгрөгийн зөрчил шийдвэрлэгдээгүй байна
- Хяналтын шатанд 344.3 сая төгрөгийн асуудал шалгагдаж байна

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2010.12.16 № 1/2839
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Манай байгууллагын 2007, 2008 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдлийн аудитын өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэнд хийсэн давтан аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Эрсдлийн аудитын өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн "Аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх тухай" 139 дугаар тушаал гарган биелэлтийг та бүхэнд хүргүүлж байсан.

Аудитын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх талаар манай байгууллагаас шалтгаалах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд тайлангийн төсөлд 137,0 сая төгрөгийн зөрчлийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй гэсэн дүгнэлт өгчээ. Энэхүү урьдчилсан дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг дахин нягтлан үзэж, тайлбар, холбогдох баримтыг хүргүүлэв.


Давтан аудитын дахин зөвлөмжинд тусгагдсан 137,0 сая төгрөгийн албан шаардлагаас 3,0 сая төгрөгийн шаардлага бүрэн хэрэгжсэн, 130,4 сая төгрөгийн шаардлага хууль хяналтын шатанд, 3,5 сая төгрөгийн шаардлага хэрэгжих шатанд байна.

Манай байгууллагын зүгээс авч хэрэгжүүлсэн 137,0 сая төгрөгийн арга хэмжээнүүдийг давтан аудитын тайланд оруулж өгнө үү.

Бид аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласнаар байгууллагын үйл ажиллагаанд тодорхой ахиц, үр дүн гарч байна.

Богино хугацаанд манай ажилтнуудад мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, хамтран ажилласан аудитор Г. Гүнжидмаа, Ш. Отгонбаяр нарт талархсанаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,



ДАРГА

Ч. АЛТАНХУЯГ

100421

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраас 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн 1/2839 дүгээр албан бичгийн хавсралт

Давтан аудитын зөвлөмжийн тайлбар

	Д/д	Зөвлөмж	Хэрэгжилт
Тайлбар 1-ийг үзнэ үү.	1	Зоос, Улаанбаатар банкнаас 119169,5 мянган төгрөгийн хүүгийн авлага үүсгэж аваагүй	Авилгатай тэмцэх газарт шалгуулахаар 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 8/2674 дугаар албан бичиг хүргүүлсний дагуу Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагчаас 2008 оны 6 дугаар сарын 23-ны өдөр “гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай” 37 дугаар мэдэгдэл ирүүлсэн. Мөрдөн байцаагчийн мэдэгдэлд эрүүгийн 20746339 тоот хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад Нийгмийн даатгалын ерөнхий газрын зарим албан тушаалтнуудын гэм буруутай үйлдлийг тогтоогоод байгаа тухай дурьдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар байгууллага дээрээ тодорхой ажил зохион байгуулах чиглэл өгсөн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2008 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн “Мэдэгдлийн хариу” 1674 дугаар албан бичгээр гүйцэтгэсэн ажлын талаар хүргүүлсэн. /3 ширхэг баримт хавсаргав./
Тайлбар 2-ыг үзнэ үү.	2	Улаанбаатар хотын даатгал ХХК-иас нөхөн төлбөрт олгосон 13016,0 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос асуудлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 1/171 дугаар албан бичиг хүргүүлсний дагуу 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 06/1257 дугаар албан бичгээр хариу өгсөн байна. Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой баримтыг дахин нягтлан үзэхэд Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн байранд 2003 оны 11 дүгээр сарын 22-ны 15 цаг 20 минутанд гарсан галын улмаас үүссэн хохирлын 1791,0 мянган төгрөгийг Улаанбаатар даатгал ХХК-иас тус хэлтэс 2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч бүртгэл, тайланд тусгасан байна. 2004 оны 1 дүгээрс сарын 13-ны өдрийн 2 цаг 45 минутанд тус хэлтсийн зуух дэлбэрснээс үүссэн хохирлын 5500,0 мянган төгрөгийн баримтын хуулийн зүйн үндэслэлийг харгалзан Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтэс 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдөр авлагаар тусгав. 2003 онд Мэдээлэл тооцоолол, сургалтын төвд даатгалтай техник тоног төхөөрөмжүүдийг зассантай холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэх асуудлыг 2010 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хууль хяналтын байгууллагад шилжүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/2830 дугаар албан бичгээр тус төвд үүрэг болголоо. /4 ширхэг баримт хавсаргав./
Тайлбар 3-ыг үзнэ үү.	3	Төв сангийн нийгмийн даатгалын шимтгэлийн ерөнд авсан барааг хүлээлцүүлэхдээ тооллого хийж, баталгаажуулаагүй, эд хариуцагчийн бусдад худалдсан бараа материалын	Эд хариуцагчаар ажиллаж байсан С. Туяа Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст ажилд орсноор 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 50,0 мянган төгрөгийг төлүүлж, Хүсэлтийн дагуу төлбөр барагдуулах график байгуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 5/2830 дугаар албан бичгээр тус дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлээ. /4 ширхэг баримт хавсаргав./

Тайлбар 4-ийг үзнэ үү.

4	3568,8 мянган төгрөгийн үнэ төлөгдөөгүй 2007 оны жилийн эцсийн тооллогоор дутагдсан 1246,4 мянган төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны “Аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх тухай” 139 тоот тушаалын дагуу шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох ажилтануудад үүрэг өгөгдсөн. Тушаалын дагуу 2004 оноос хойшхи хугацааны Нийгмийн даатгалын ерөнхий газрын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн тайланг нэг бүрчлэн тулгаж, дахин нягтлан үзэв. 2005 онд шинээр худалдан авсан тавилга, эд хогшлыг баримтын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан боловч Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2005 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн “үнийн зөрүү”-ийн орлогоор 1246,4 мянган төгрөгийг давхардуулан тусгагдсан байна. Иймд холбогдох баримтыг үндэслэн 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 1246,4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулах бичилтийг хийлээ. /15 ширхэг баримт хавсаргав./
---	---	---

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын саналд өгөх тайлбар:

Тайлбар 1

УНДЕГ, Зоос банкны эрх хүлээн авагчаас ирүүлсэн албан бичгээр 2006, 2007 онд Зоос банк УНДЕГ-ын харилцах дансны үлдэгдэлд гэрээний дагуу хүүг төлсөн, тухайн онуудад үүссэн өглөг, авлагын тооцоогүй болохыг тодорхойлсон тул тайланд өөрчлөлт орууллаа.

Харин Улаанбаатар банкаас харилцах дансны үлдэгдэлд хүүгийн авлага үүсгэж аваагүй 70000.0 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулаагүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 2

Тайлангийн төсөлд санал авах хугацаанд зөрчлийг барагдуулах арга хэмжээ авсан тул тайланд өөрчлөлт орууллаа.

Тайлбар 3

Сонгинохайрхан дүүргийн НДХ-ийн орлого, шимтгэлийн байцаагч С.Туяатай төлбөр барагдуулах график байгуулан, төлбөрийг цалингаас нь суутган УНДЕГ-ын Төрийн сан дахь 900090001 дугаар дансанд төвлөрүүлэх арга хэмжээ авсан тул тайланд өөрчлөлт орууллаа.

Тайлбар 4

2005 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн үнийн зөрүүгийн орлогоор 1246.4 мянган төгрөгийг давхардуулан тусгасан нь холбогдох баримтаар нотлогдож 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдөр залруулах бичилтийг хийсэн тул тайланд өөрчлөлт орууллаа.

Зөвлөмж:

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн биелүүлж, Улаанбаатар банкнаас 70.0 сая төгрөгийн хүүгийн авлага үүсгэж аваагүй зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт дахин зөвлөж байна.